



ДҮГНЭЛТ

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ажилтан, албан хаагчдын харилцаа, хандлага”-ын талаарх судалгааг 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд цахимаар авч, үр дүнг нэгтгэв. Судалгаанд нийт 43 ажилтан, албан хаагч хамрагдсан ба судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл:

- ✓ Ажилтан, албан хаагчид холбогдох хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ёс зүйн хэм хэмжээг баримталж иргэн, Аж ахуйн нэгж байгууллагуудад хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэн ажилладаг болох нь харагдаж байгаа ба албан хаагчдад хууль бус туслалцаа хүсэх магадлалтай хүмүүс нь ажил, амьдралын хамгийн ойрын хүрээлэл буюу удирдах албан тушаалтан болон найз, нөхөд байдаг байна.
- ✓ Судалгааны асуумж болон нэмэлт саналуудаас харахад судалгаанд оролцогчдын олонх нь хамт олны дунд харилцаа, хандлага, үг үйлдлээрээ бусдыг хүндэтгэдэггүй ёс зүйн хэм хэмжээг зөрчдөг албан хаагчид байна гэж үзсэн.
- ✓ Судалгаанд оролцогчдын олонх нь зарим албан хаагчид хувцаслалтдаа анхаарах хэрэгтэй гэж хариулсан нь ажлын байранд зохистой хувцаслах нь ёс зүйтэй байгааг илтгэдэг гэдгийг харуулж байна.

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

2025.09.18



ЗӨВЛӨМЖ

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ажилтан, албан хаагчдын харилцаа, хандлага”-ын талаарх судалгааны үр дүнг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Нийт ажилтан, албан хаагчид авлига, ашиг сонирхлоос ангид байж, холбогдох хууль тогтоомжийг тогтмол судлан, мэдлэг, мэдээлэлтэй байж өөрийгөө эрсдэлээс хамгаалах,

Албан хаагч нь ажлын байранд, ажлын цагаар хувцаслалт, биеэ авч явах байдал, харилцаа, хандлага, ажлын арга барил, үг, үйлдлээрээ хамт олондоо зөв үлгэрлэл үзүүлж, манлайлан ажиллах,

Албан хаагчид харилцаа, хандлага, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр хүнд, хууль ёсны ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандаж, ажлын байранд, хамт олны дунд ажил хэрэгч, эерэг уур амьсгал бүрдүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн, бусдыгаа манлайлан ажиллах,

Удирдах албан тушаалтан, ахлах мэргэжилтэн, инженерүүд ажилтан, албан хаагчидтай харилцах харилцаа хандлагадаа анхаарч, тэгш, шударга ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан багаар ажиллах, зөөлөн ур чадварыг сайжруулах замаар үлгэрлэн манлайлах арга барилыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх,

Газраас ажилтан, албан хаагчдын хувь хүний хөгжлийг дэмжих, соён гэгээрүүлэх, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр олон талт сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг. Иймд нийт албан хаагчид болон нэгжийн дарга нар Газраас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд ач холбогдол өгч, тухай бүр сургалтад бүрэн хамрагдаж, мэдлэг, мэдээлэл авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг тус тус зөвлөж байна.

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

2025.09.18